



BLUE MONGOLIA BUIR KO-15 June 28-30, 2026

Олон улсын
задгай усан сэлэлтийн тэмцээн

Бүртгүүлэх

+976 94113995

kingsofocean720@gmail.com



ОЛОН УЛСЫН ЗАДГАЙ УСАН СЭЛЭЛТИЙН ТЭМЦЭЭН

"BLUE MONGOLIA BUIR KO-15"

(Клубын 15 жилийн ойн хүрээнд)

1. ТЭМЦЭЭНИЙ МЭДЭЭЛЭЛ

Тэмцээн: Blue Mongolia Buir KO-15

Зохион байгуулагч: "Далайн Хаадууд" клуб

Эхлэх, дуусах, он, сар, өдөр: 2026.06.28-2026.06.30

Он сар өдөр	Гараг	Цагийн хуваарь
2026.06.28	Ням	09:00
2026.06.29	Даваа	09:00
2026.06.30	Мягмар	09:00

Байршил: Дорнод аймаг, Халхгол сум, Буйр нуур

Усны температур: 18°C 2.

2. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

2.1 "Blue Mongolia Buir KO-15" задгай усан сэлэлтийн тэмцээн нь "МУССХ-ны Тэмцээний дүрэм"-ийн дагуу явагдана.

2.2. Тэмцээнийг ганцаарчилсан болон багийн буухиа төрлөөр зохион байгуулна

3. НАСНЫ АНГИЛАЛ

3.1 Насны бүлэг: 14-15 нас, 16-17 нас, 18-19 нас, 20-24 нас, 25-29 нас, 30-34 нас, 35-39 нас, 40-44 нас, 45-49 нас, 50+ нас

3.2 Буухиа насны бүлэг: Өсвөр үе, Насанд хүрэгсэд

3.3 Насны бүлгийг 2026 оны 12 сарын 31-ний өдрөөр тооцно.

3.4 Тамирчид зөвхөн өөрийн насны бүлэгт өрсөлдөнө.

3.5 Зохион байгуулагчид тухайн тамирчны бичиг баримтыг шаардаж, насны бүлгийг баталгаажуулан шалган эрхтэй бөгөөд зөрчил гарсан тохиолдолд тэмцээнээс хасах арга хэмжээг авч, ёс зүйн зөвлөлд шилжүүлэн хариуцлага тооцно.

Насны бүлэг	Төрсөн он
14-15	2012-2011
16-17	2010-2009
18-19	2008-2007
20-24	2006-2002
25-29	2001-1997
30-34	1996-1992
35-39	1991-1987
40-44	1986-1982
45-49	1981-1977
50-54	1976-1972
55-59	1971-1967
60-64	1966-1962
65-69	1961-1957
70-74	1956-1952
75+	1951+ өмнө

4. ТЭМЦЭЭНИЙ БҮРТГЭЛ

4.1 Доорх шаардлагыг хангасан клуб/тамирчин тэмцээнд оролцох эрхтэй.

Тэмцээний бүртгэлийн хураамжийг төлсөн байх

- Тэмцээнд уралдах төрөл/зай тус бүрт: 50,000₮
- Хураамжийг: MN(45003200)5003415374 тоот Хас банкны “Далайн хаадууд усан сэлэлтийн төв” дансанд тушаах, Утга: нэр, утас

4.2 Тэмцээний бүртгэлийн маягтыг 2026 оны 06-р сарын 15-ны өдрийн 23:59 цагаас өмнө доорхи мэйлээр илгээсэн байх.

4.3 Бүртгэлийн хураамжаа төлж, мэдүүлгээ тогтоосон хугацаанд гаргасан бүх тамирчид оролцох эрхтэй.

Бүртгэлийн маягтыг:

<https://forms.gle/PwjkeP3F5beSL09> линк эсвэл

доорх QR code-р орон үнэн зөв бөглөн илгээнэ.



Бүртгэлийн маягтыг бөглөх заавар:

Овог *

Short answer text

Улаан тэмдэглэгээтэй хэсгийг заавал бөглөнө үү. Ингэснээр таны мэдээлэл илгээгдэх болно.

- 4.4 Техникийн зөвлөгөөнд бүх багийн ахлагч болон тамирчид оролцох үүрэгтэй.
- 4.5 Багийн ахлагч нар болон тамирчид гарааны хуваарь гарсны дараа өөрийн бүртгэлийг нягталж, ямар нэг алдаа гарсан байвал яаралтай зохион байгуулагчдад мэдэгдэх үүрэгтэй.
- 4.6 Тамирчид тэмцээнд оролцохын өмнө хувийн аюулгүй байдал, хариуцлагын журам, заавартай танилцаж гарын үсэг зурсанаар тэмцээнд оролцох эцсийн байдлаар нээгдэнэ.

5. БУЦААЛТ

- 5.1 Эрүүл мэндийн шалтгаанаас бусад тохиолдолд тамирчин гараанд гараагүй бол тамирчныг 50,000₮-өөр торгоно.
- 5.2 Эрүүл мэндийн шалтгаанаар гараанд гараагүй тамирчин тухайн өдрийн бусад гараанд оролцох эрхгүй.
- 5.3 Багийн ахлагч гараанд гараагүй тамирчны маягтыг бөглөж, эрүүл мэндийн магадлагааны хамт гараа эхлэхээс 30 минутаас багагүй хугацааны өмнө Ерөнхий шүүгчид хүргүүлсэн байна.
- 5.4 Тэмцээнийг зохион байгуулагчдын буруутай үйлдлээс болж баг/тамирчин ямар нэг алдаа гаргаж шийтгэл хүлээсэн нь тогтоогдвол бг/тамирчны шийтгэлийг нэн даруй хүчингүй болгож амжилтыг сэргээж, цаашид тэмцээнээ үргэлжлүүлэх боломжоор хангана.

6. ШАГНАЛ

- 6.1 задгай усанд сэлэлтийн тэмцээний шагналыг дараах байдлаар олгоно.
- 6.2 Ганцаарчилсан уралдааны эхний гурван байранд Алт, Мөнгө, Хүрэл медаль, Диплом, Мөнгөн шагнал
- 6.3 Багийн буухиа уралдааны эхний байранд орсон багт “Blue Mongolia Buir KO-15” шилжин явах цом, диплом
- 6.4 Бүх тамирчдад “Finisher” сертификат олгоно
- 6.5 Тамирчид/багууд ижил цагийн амжилт үзүүлсэн бол медалийг доорх байдлаар олгоно.

Нэгдүгээр байрны тамирчдын цаг ижил бол:

2 Алт	Мөнгө байхгүй	1 Хүрэл
-------	---------------	---------

Хоёрдугаар байрны тамирчдын цаг ижил бол:

1 Алт	2 Мөнгө	Хүрэл байхгүй
-------	---------	---------------

Гуравдугаар байрны тамирчдын цаг ижил бол:

1 Алт	1 Мөнгө	2 Хүрэл
-------	---------	---------

Хэрэв гурван тамирчин ижил цагийн амжилт гаргасан бол медалийг доорх байдлаар олгоно.

Нэгдүгээр байрны тамирчдын цаг ижил бол:

3 Алт	Мөнгө байхгүй	Хүрэл байхгүй
-------	---------------	---------------

Хоёрдугаар байрны тамирчдын цаг ижил бол:

1 Алт

3 Мөнгө

Хүрэл байхгүй

Гуравдугаар байрны тамирчдын цаг ижил бол:

1 Алт

1 Мөнгө

3 Хүрэл

7. ТЭМЦЭЭНИЙ БАЙРШИЛ

7.1 Дорнод аймаг, Халхгол сум, Буйр нуур

Холбогдох утас: 94113995

8. БИЕ ХАЛААЛТЫН ЗААВАР

8.1 Тэмцээн эхлэхээс 90 минутын өмнө тамирчдын бие халаалт эхэлнэ.

8.2 Бие халаалтын журмын биелэлтийг Ерөнхий шүүгч хянаж ажиллана.

8.3 Баг тамирчид зөвхөн зохион байгуулагчдын гаргасан хуваарийн дагуу халаалтаа хийх бөгөөд багийн ахлагчид хяналт тавих үүрэгтэй.

8.4 Тамирчид нуурын ирмэг дээр суусан байрлалаас хөлөөрөө ус руу орно. Ус руу үсэрч орохыг хатуу хориглоно.

8.5 Бие халаалтын үед сэлүүр ашиглахыг хориглоно.

8.6 Дасгалжуулагчид бие халаалтын журам болон аюулгүй байдлын зааварчилгааг тамирчиддаа өгөх үүрэгтэй бөгөөд бие халаалтын үеэр байнга хамт байж аюулгүй байдалд хяналт тавина.

8.7 Бие халаалтын журам зөрчсөн тамирчныг Ерөнхий шүүгч болон тэмцээний зохион байгуулагчид усан сангаас нэн даруй гаргана.

9. ЭСЭРГҮҮЦЭЛ

9.1 Эсэргүүцэл илэрхийлэх боломжтой.

9.2 Эсэргүүцлийг доорхи тохиолдолд гаргаж болно.

а. Тэмцээний дүрэм, зохион байгуулах журам тодорхой биш

б. Тамирчдад ямар нэг эрсдэл үүссэн бол

в. Шүүгчийн шийдвэрийг эсэргүүцэж болно. Гэвч баримтад тулгуурласан шийдвэрийг эсэргүүцэхийг хориглоно.

9.3 Эсэргүүцэл мэдүүлэхдээ дараах зүйлсийг анхаарна. Үүнд:

а. Ерөнхий шүүгчид мэдүүлэх

б. Маягтан дээр эсэргүүцлийг бичсэн байх

в. Багийн ахлагч мэдүүлгийг бөглөх

г. Тухайн уралдаан болсноос хойш 30 минутын дотор

9.4 Дүрмийн дагуу мэдүүлсэн эсэргүүцлийг дараагийн үйл ажиллагаа болон

тэмцээний гараа эхлэхээс өмнө шийдвэрлэнэ.

9.5 Бүх эсэргүүцлийг Ерөнхий шүүгч хянаж шийдвэрлэнэ. Ерөнхий шүүгч эсэргүүцлийг хүлээж авахгүй байх шийдвэр гаргасан бол шалтгааныг тайлбарлах үүрэгтэй.

10. ТЭМЦЭЭНИЙ ТӨРӨЛ

Хувийн гараа

Нас	Холын зай			
	500 м	1500 м	3000 м	5000 м
14-15	+	+		
16-17	+	+	+	
18-19	+	+	+	+
20-24	+	+	+	+
25-29	+	+	+	+
30-34	+	+	+	+
35-39	+	+	+	
40-44	+	+		
45-49	+	+		
50-54	+	+		
55-59	+	+		
60-64	+	+		
65-69	+	+		
70-74	+	+		
75+	+	+		

Багийн буухиа гараа

Ангилал	Нас	Хүйс	Нэг хүний гараа	Нийт гараа
Өсвөр үе		2 эр, 2 эм	500 метр	2000 метр
Насанд хүрэгсэд		2 эр, 2 эм	1500 метр	2000 метр

Гэр бүлийн тэмцээн: Аав + Ээж + Хүүхэд (5-10 нас)

11. ТЭМЦЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

6-р сарын 27: Тамирчдыг хүлээн авах, мандат олгох, Техникийн зөвлөгөөн, Нээлтийн шоу

6-р сарын 28: Ганцаарчилсан гараанууд (1500, 3000 метр)

6-р сарын 29: Холын зайн сэлэлт (500, 5000 метр)

6-р сарын 30: Багийн буухиа тэмцээн, Гэр бүлийн уралдаан, Шагнал гардуулах ёслол, Хаалтын ажиллагаа

12. ТЭМЦЭЭНИЙ ХУВЦАС ХЭРЭГЛЭЛ

- 12.1 Усанд сэлэлтийн хувцас нь усны хэм 18 °C болон түүнээс доош бол World Aquatics-ийн дүрмээр Wetsuit өмсөх нь албадан заалт болно.
- 12.2 Усны өмсгөлийн өнгө тунгалаг/гэрэлтэж харагдаж болохгүй. 2 давхар малгай өмсч болно.
- 12.3 Тамирчны малгай, шил нь усан сэлэлтийн төрөлд тохирсон байх бөгөөд ямар нэгэн сөрөг сэтгэгдэл төрүүлэхүйц тэмдэг, тэмдэглэгээгүй байна.
- 12.4 Тэмцээний үеэр тамирчин хурд, хөвөх чадвар, тэсвэр хатуужилд туслах ямар нэгэн төхөөрөмж, усны хувцас ашиглахыг хориглоно.
- 12.5 Гэмтлийн улмаас хоёроос илүүгүй хөлийн хурууг нааж болно. Ерөнхий шүүгч зөвшөөрснөөс бусад тохиолдолд тамирчин бие дээрээ ямар нэг наалт наахыг хориглоно.
- 12.6 Бие дээрх ямар нэг таних тэмдэг, сурталчилгааг хориглоно.
- 12.7 Тамирчны харъяалагдах байгууллага, клубын нэр болон таних тэмдгийг зар сурталчилгаанд тооцохгүй.
- 12.8 Оролцогч бүр хамгаалалтын хөвүүр (Safety Buoy) заавал зүүнэ.
- 12.9 Энэхүү дүрмийн ерөнхий шаардлагыг илт зөрчсөн хувцас хэрэглэлтэй тамирчинд Ерөнхий шүүгч зөрчлийг арилгах шаардлага тавих бөгөөд шаардлагыг биелүүлээгүй бол тэмцээнээс хасах эрхтэй.

13. ТЭМЦЭЭНД ОРОЛЦОГЧДЫН ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

- 13.1 Тэмцээнд оролцогчид тамирчид, дасгалжуулагчид, баг хамт олон, эцэг эхчүүд болон хөгжөөн дэмжигчид доорх хэм хэмжээг баримтална.
- 13.2 Үнэнч шударгаар өрсөлдөж, ёс зүйн аливаа зөрчил гаргахаас зайлсхийх
- 13.3 Усан спортыг гутаан доромжлох, усан спорт болон МУССХ-ны нэр хүндийг унагаах үйлдэл/эс үйлдэл хийхээс зайлсхийх
- 13.4 Тэмцээнийг зохион байгуулагчид болон бусад тамирчид, хэвлэл мэдээлэл болон үзэгчдийн эсрэг заналхийлсэн, хүчирхийлсэн, үл хүндэтгэсэн зан авир гаргахгүй байх.
- 13.5 Бусдыг үндэс угсаа, арьсны өнгө, нас хүйс, шашин шүтлэг, хэл соёл, хувийн үзэл бодол, өмч хөрөнгө, хөгжлийн бэрхшээл болон бусад бүх үндэслэлээр ялгаварлан гадуурхахаас зайлсхийх.
- 13.6 Тэмцээний үйл ажиллагаа, зохион байгуулалтад саад учруулах, хөндлөнгөөс оролцох, тогтоосон дэгийг зөрчихгүй байх. Энэ заалт нь тухайн арга хэмжээ болж буй бүх хэсэгт хамаарна.
- 13.7 Тэмцээний бүхий л үйл ажиллагаа буюу нээлт, хаалт, шагнал гардуулах ёслолд идэвхтэй оролцох.
- 13.8 Сэргээшийн эсрэг хөтөлбөрийг дэмжиж, дэлхийн сэргээшийн эсрэг дүрмээр хориглосон ямар нэг бэлдмэл, зан үйлийг ашиглахгүй байх

13.9 Согтууруулах ундаа, угаат болон цахилгаан тамхи (vape) хэрэглэхийг хатуу хориглоно. Энэ заалт нь тухайн арга хэмжээ болж буй бүх хэсэгт хамаарна.

13.10 Тамирчдын насыг санаатайгаар буруу мэдээлэх, холбогдох баримтыг засварлах, хуурамчаар үйлдэхгүй байх.

13.11 Эдгээр ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн аливаа үйлдэл/эс үйлдлийг тэмцээнийг зохион байгуулах хороонд мэдэгдэж хамтран ажиллах

14. ТАМИРЧНЫ ХАРЪЯАЛАЛ, БАЙГУУЛЛАГА, КЛУБЫН ТӨЛӨӨЛӨХ ЭРХ

14.1 Аливаа байгууллага, клубыг төлөөлөн оролцохын тулд тамирчин нь:

- Тухайн байгууллага, клубын гишүүн байх
- Тамирчин нь ивээн тэтгэгч байгууллагын нэрийг ашиглаж болно.

14.2 Тамирчин нь тухайн байгууллага, клубын гишүүн боловч 14.1-д заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд тухайн байгууллага клубыг төлөөлөх эрхгүй бөгөөд МУССХ-ны зөвшөөрлөөр зөвхөн хувиараа тэмцээнд оролцох эрхтэй.

ТАМИРЧНЫ ЭРҮҮЛ МЭНД, ХАРИУЦЛАГЫН ХУУДАС (WAIVER FORM)

Энэхүү хуудсан дээр тамирчин бүр гараанд гарахаас өмнө гарын үсэг зурж, мандатаа авна. Тэмцээний нэр: Blue Mongolia Buir KO-15

Оролцогчийн нэр: _____ Нас: __ Хүйс: __

Би задгай усанд сэлэлтийн тэмцээн нь бие махбодоос өндөр ачаалал шаарддаг болохыг хүлээн зөвшөөрч байна. Миний бие эрүүл мэндийн хувьд ямар нэгэн саадгүй бөгөөд 18°C-ийн хүйтэн усанд сэлэх чадвартай болохоо баталж байна. Тэмцээний явцад өөрийн буруутай үйлдэл эсвэл эрүүл мэндийн байдлаас шалтгаалан үүсэж болох аливаа эрсдэлийг би өөрөө бүрэн хариуцна. Би тэмцээний аюулгүй байдлын дүрэм (хөвүүр зүүх, замаас гарахгүй байх)-ийг чанд мөрдөнө.

Гарын үсэг: _____

(Хэрэв 18 насанд хүрээгүй бол эцэг эх, асран хамгаалагч гарын үсэг зурна)

Огноо: 2026.06.27